

Агуулга

I.Оршил

I.1 Нэр томъёоны товч тайлбар, тодорхойлолт3
I.2.Эдийн засагт ХАА-н салбарын эзлэх байр суурь8
I.3.Газар тариалангийн салбарын үйлдвэрлэлт10

II.Мал аж ахуй

II.1.2012 оны мал тооллогын дүн11
II.2 .Малын хэрэглээний зарлага20
II.3.Төл бойжилт21
II.4.Том малын зүй бус хорогдол24
II.5.Иргэдийн малын бүлэглэлт27
II.6.Шинээр гаргасан, засварласан худгийн тайлан29
II.7.Малжуулалтын талаар авсан арга хэмжээ31
II.8.Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж32
II.9.Малчдын нийгэм, ахуйн үзүүлэлт33
II.10.Малчдын тоо, насны бүлгээр35
II.11.Малтай өрх, малчин өрх36
II.12.ХАА-н салбарын ажиллах хүч37

III.Газар тариалан

III.1.Тариалсан талбай38
III.2.Хураасан ургац39

IV.Дүгнэлт

Танилцуулгыг хянан, тохиосон:

Б.Дэмид-Очир

Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:

Д.Жавзанлхам

Санал хүсэлт байвал доорх

Хаягаар холбоо барина уу.

Дархан-Уул аймгийн Статистикийн хэлтэс

Засаг даргын тамгын газрын байр

E-mail:Darkhan-Uul@nso.mn

Утас:70377031 70377763

Интернет хаяг://www.nso.mn/Darkhan-Uul/

Дархан-Уул аймаг Статистикийн хэлтэс

Дархан хот 2013 оны 3-р сар

ОРШИЛ

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр үрийн сорт, байгаль цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгддэг.

Энэ удаагийн танилцуулгад мал аж ахуй, газар тариалангийн салбарын 2012 оны төлөв байдлыг нэгтгэн тусгалаа.

“Монгол Улсын Үндсэн хууль”-нд “Мал сүрэг “ –ийг үндэсний баялаг мөн гэж хуульчлан зааж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Үндэсний Статистикийн хороо мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогыг 2012 оны 12 сарын 7-ноос 17-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулж, явууллаа.

Малын 2012 оны тооллогын маягтыг өмнөх жилүүдийн тооллогоос арай хураангуй байдлаар өөрчилэн шинэчилж, зааврын дагуу явуулж, үр дүнг нэгтгэн гаргалаа.

Энэхүү танилцуулгад малын 2012 оны тооллогын дүнг нэгтгэн дүгнэхээс гадна мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, голлох нэр төрлийн түүхий эд үйлдвэрлэлийн хэмжээ, шинээр гаргасан, уст цэг, малжуулалтын талаархи мэдээллийг тусган орууллаа.

Түүнчлэн уг танилцуулгад газар тариалангийн салбарын үндсэн үзүүлэлтүүд болох тариалсан талбай, хураасан ургац, га-гийн ургацын талаарх мэдээллийг жилийн дүнгээр нэгтгэн тусгасан болно.

Салбарын бүтцээр анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар, үүний дотороо мал аж ахуйн салбар 1999 он хүртэл ДНБ-ий 30-40 орчим хувийг үйлдвэрлэж, 2000 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшиг, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж, хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувийн жин буурч, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хувийн жин өссөөр байна.

Хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь боловсруулах аж үйлдвэрийн салбарын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэхмэл эдлэл үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийг нийлүүлж, боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, газар тариалангийн салбар нь хүн амыг аюулгүй баталгаат хүнсээр хангах үндсэн нөхцөл нь болсоор байна.

Манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэж байна.

I.1.Нэр томъёоны товч тайлбар, тодорхойлолт

Малтай өрх. Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр -1 бод

1 тэмээ -1,5 бод

6 хонь – 1 бод

8 ямаа -1 бод

Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1тэмээ -5 хонь

1 адуу-7 хонь

1үхэр -6 хонь

1 хонь-1 хонь

1 ямаа-0,9 хонь

Богд шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

Нас гүйцсэн мал. Малын төрөл бүр дээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ – 4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу-3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр -2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал- тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал

Тэмээ –өмнөх оны төл 2,3 настай

Адуу-Өмнөх оны төл, 2настай

Үхэр- Өмнөх оны төл

Төл мал. Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ.

Малын өсөлтийн **Орлого тал** нь төл бойжилт, **Зарлага тал** нь хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100-гаар үржүүлэн тооцно.

Бойжилтын хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж, тооцно.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь: Буур 20-25, Азарга 12-15, Бух 35-45, Хуц, Ухна 25-30

Том малын зүй бус хорогдолд Өвчний /халдвартай, халдваргүй/ хорогдол, гэнэтийн аюулын /Цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг / хорогдол, бусад шалтгааны /малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан/ хорогдлыг хамруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Малын хэрэглээний зарлага Оны эхний малын тоо дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч, тооцно.

Малын хашааны хангамж. Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулж тооцно. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

Тэжээл хангамж Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан тооцно. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлснээр тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд: Хадлан өвс -0.45, Таримал тэжээл -0.35, Даршны ургамал -0.25, Гар тэжээл хужир шүү -1.00, Төмс ногооны хаягдал 0.22, Үр тарианы хаягдал 0.90, Лай -0.40, Сүрэл -0.25 гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Малын тэжээлийн ангилал Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.

1. Бүдүүн тэжээл –өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
2. Хүчит тэжээл –үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
3. Шүүст тэжээл –Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.

- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил орно.

- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Тариалангийн талбай Хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

Тариалсан талбай. Тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Хураасан талбай. Тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ

Га-гийн ургац Талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын / хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо тухайн төрлийн ургамлын хурааж авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулж тодорхойлоно.

Нийт ургац Тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл, тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.


1.2.ЭДИЙН ЗАСАГТ ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

2012 онд цаг агаарын байдал тааламжтай байж оны эцсийн тоолуулсан малын тоо 4.5 хувиар өсөж хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 27.2 хувь буюу 9.9 сая төгрөгөөр өслөө. Өнгөрсөн жилд цаг агаарын байдлаас шалтгаалж, га-аас авах ургац нэмэгдэж, зүй бусаар хорогдсон малын тоо буурч, мал аж ахуйн голлох үйлдвэрлэл болох бойжуулсан төлийн тоо өссөн нь хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн энэхүү өсөлтөд голлон нөлөөлсөн байна.

Аймгийн ДНБ болон ХАА-н салбарын нэмэгдэл өртөг, эзлэх хувь хэмжээ /сая.төг/

	2008	2009	2010	2011	2012	2012/2011	
						%	зөрүү
Бүгд	135379.7	127433.6	184626.9	201347.8	254746.4	126.5	53398.6
ХАА, ойн аж ахуй, ан агнуур	25316.0	27653.1	30278.8	36242.6	46109.1	127.2	9866.5
ДНБ-ний дүндээ эзлэх хувь	18.7	21.7	16.4	18.0	18.1	100.0	0.0

ХАА-н салбарын нэмэгдэл өртөг / сая.төг/



Салбарын бүтцээс үзвэл анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар дотороос мал аж ахуйн салбар аймгийн ДНБ 60-70 орчим хувийг үйлдвэрлэж, 2006 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшиг, үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж, хөдөө аж ахуйн салбарын ДНБ-нд эзлэх хувийн жин буурч, үүний оронд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хувийн жин өсч байна.

Мах нядалгааны жингээр 2012 онд 6885.9 тн мах, 6218.3 тн сүү, 23.9 тн ноолуур, 151.7 тн хонины ноос, 3.7 тн хөөвөр, 7.4 тн хялгас 1.4 тн эм ноос, 97.9 мянган ширхэг арьс, шир үйлдвэрлэсэн нь 2011 оныхоос мах 2 дахин буюу 3472.5 тн, арьс, шир 97.8 хувь буюу 48.4 мянган ширхэгээр, хөөвөр 5.7 хувь буюу 0.2 тн, сүү 12.9 хувь буюу 710.5 тн, хонины ноос 8.7 хувь буюу 12.2 тн-оор нэмэгдсэн бол, эм ноос 17.6 хувь буюу 0.3 тн-оор буурсан байна.

Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, биет хэмжээгээр /мян.төг/

	2010	2011	2012	2012/2011	
				%	зөрүү
<u>Мах ,нядалгааны жингээр, тн</u>	2619507.2	2297676.1	4610293.3	2 дах	2312617.2
Тэмээний	5873.4	10993.8	24698.4	2 дах	13704.6
Адууны	138694.5	136533.6	261255.5	191.3	124721.9
Үхрийн	1262460.6	1135458.3	2372441	2 дах	1236982.7
Хонины	769017.6	724888.3	1227480.8	169.3	502592.5
Ямааны	438117.1	276056.1	707349.1	2 дах	431293
Гахай	4879.0	12971	15053.5	116.1	2082.5
Шувуу	465.0	775	2015	2 дах	1240
<u>Ноос, тн</u>	708941.8	773699.9	764808.5	98.9	-8891.4
Тэмээний ноос	542.5	383.6	328.4	85.6	-55.2
Хонины ноос	32186.3	31523.7	34292.8	108.8	2769.1
Ноолуур	671804.2	737071.3	725344	98.4	-11727.3
Хөөвөр	761.4	799.1	836.1	104.6	37
Хялгас	3647.4	3922.2	4007.2	102.2	85
<u>Арьс мян, шир</u>	665935.2	357711.8	732536.4	2дах	374824.6
Тэмээ	415.0	674.3	1348.6	2 дах	674.3
Адууны	26657.1	22332.3	41654.1	186.5	19321.8
Үхэр	151877.2	96360.9	198711.9	2 дах	102351
Хонь	191324.5	128415.2	215402.4	167.7	86987.2
Ямаа	264162.9	109767.7	274721	2 дах	164953.3
Хурга	29075.2	142.1	588.8	4 дах	446.7
Ишиг	2423.3	19.3	109.6	5 дах	90.3

1.3. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН 2012 ОНЫ БҮТЭЭГДЭХҮҮН

		Дундаж үнэ /мян.төг/	Бүгд		Хувийн аж ахуй		Бусад	
			тонн	үнэ	тонн	үнэ	тонн	үнэ
Үр тариа								
Үүнээс	Буудай	102.2	12820.8	1310285.8	10070.2	1029174	2750.6	281111.3
	Бусад	150	600	90000.0	400.3	60045	199.7	29955
	Дүн		13020.5	1400285.8	10070.2	1089219	2950.3	311066.3
Төмс			14208	1704960.0	1890	226800	12318	1478160
Хүнсний ногоо								
Үүнээс	Байцаа	123	507	62361.0	26.2	3222.6	480.8	59138.4
	Манжин	108	1570.6	169624.8	521.6	56332.8	1049	113292
	Лууван	151.0	8966.5	1353941.5	756.4	114216.4	8210.1	1239725
	Сонгино	255	674.9	172099.5	138	35190	536.9	136909.5
	Сармис	542	0	0.0	0	0	0	0
	Өргөст хэмх	440	665.8	292952.0	10.6	4664	655.2	288288
	Улаан лооль	589	30.5	17964.5	0	0	30.5	17964.5
	Тарвас	140	0	0.0	0	0	0	0
	Бусад	340.0	651.6	221544.0	6.2	2108	645.4	219436
	ДҮН		12928.9	2290487.3	1321	215733.8	11607.9	2074754
Малын тэжээл								
Үүнээс	Хадлан	24.5	71734.9	1757505.1	3611	88469.5	68123.9	1669036
	Гар тэжээл	29.9	501	14979.9	0.3	9	500.7	14970.9
	ДҮН		72235.9	1772485	3611.3	88478.5	68624.6	1684007
Жимс, жимсгэнэ								
Үүнээс	Чацаргана	746	16	11936	3.4	2536.4	12.6	9399.6
	Үхрийн нүд	641	6	3846	0.3	192.3	5.7	3653.7
	Дүн		22	15782	3.7	2728.7	18.3	13053.3

II.2012 ОНЫ МАЛ ТООЛЛОГЫН ДҮН

II.1.МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, СҮРГИЙН БҮТЭЦ

Малын тоо. 2012 оны жилийн жилийн эцсийн мал тооллогын дүнгээр малын тоо 268.4 мянган толгойд хүрч, өмнөх оныхоос 4.5 хувиар буюу 11559 толгойгоор өслөө. Үүнд адуу 281, үхэр 1748, хонь 10979 толгойгоор тус тус нэмэгдэж, тэмээ 73, ямаа 1376 толгойгоор тус тус буурч. Өнгөрсөн онтой харьцуулахад 2012 онд Дархан, Хонгор Шарын гол сумдууд малын тоо 1.5- 13.3 хувь буюу 558-9416 толгойгоор өсч, Орхон сумын малын тоо 29.4 хувь буюу 10842 толгойгоор буурсан байна.


МАЛЫН ТОО, ТӨРЛӨӨР

	2008	2009	2010	2011	2012	2012/2011	
						%	зөрүү
Бодоор/мян.тол/	88.3	95.7	74.9	76.8	80.2	104.4	3.4
Толгойн тоо	345292	361532	249821	256810	268369	104.5	11559
Тэмээ	501	440	717	507	434	85.6	-73
Адуу	10427	11054	10195	10972	11253	102.6	281
Үхэр	32591	37548	32470	33861	35609	105.2	1748
Хонь	163008	176527	127614	124987	135966	108.8	10979
Ямаа	138765	135963	78825	86483	85107	98.4	-1376

МАЛЫН ТОО, СУМААР

	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Дархан	79883	242	3154	13368	36726	26393
Хонгор	125514	3	5455	11611	70874	37571
Орхон	25970	189	881	5970	11154	7776
Шарын гол	37002	0	1763	4660	17212	13367
ДҮН	268369	434	11253	35609	135966	85107

МАЛЫН ТОО



2012 онд улсын хэмжээнд нийт 40920.9 мянган толгой мал тоологдсны 0.7 хувийг манай аймаг эзэлж байна. Үүнээс, тэмээ 0.1 хувь, адуу 0.5 хувь, үхэр 1.4 хувь, хонь 0.7 хувь, ямаа 0.5 хувийг тус тус эзэлж байна.

МАЛЫН ТОО, УЛСЫН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ

/мян.тол/

	Малын тоо /Аймгийн дүнгээр/			Малын тоо дүнгээр/			Улсын Улсын дүнд эзлэх %		
	2010	2011	2012	2010	2011	2012	2010	2011	2012
Бодоор	74.9	76.8	80.2	8424.8	9242.6	10337.3	0.9	0.8	0.8
Толгойн тоо	249.8	256.8	268.4	32729.5	36335.8	40920.9	0.8	0.7	0.7
Тэмээ	0.7	0.5	0.4	269.6	280.1	305.8	0.3	0.2	0.1
Адуу	10.2	11.0	11.3	1920.3	2112.9	2330.4	0.5	0.5	0.5
Үхэр	32.5	33.9	35.6	2176.0	2339.7	2584.6	1.5	1.4	1.4
Хонь	127.6	125.0	136.0	14480.4	15668.5	18141.4	0.9	0.8	0.7
Ямаа	78.8	86.5	85.1	13883.2	15934.6	17558.7	0.6	0.5	0.5

ХУВИЙН МАЛЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ

	2008	2009	2010	2011	2012	2012/2008		2012/2011	
						%	өсөлт	%	өсөлт
Малтай өрхийн тоо	2494	2746	2883	2752	2412	96.7	-82	87.6	-340
Бодоор	85242	93013	72542	75238	78276	91.8	-6966	104.0	3038
Толгойн тоо	332716	351035	241577	248990	258800	77.8	-73916	103.9	9810
Тэмээ	418	372	639	424	385	92.1	-33	90.8	-39
Адуу	10115	10792	10060	10828	10960	108.4	845	101.2	132
Үхэр	32228	37120	32192	33690	35165	109.1	2937	104.4	1475
Хонь	153018	168210	120673	118344	128595	84.0	-24423	108.7	10251
Ямаа	136937	134541	78013	85704	83695	61.1	-53242	97.7	-2009


НИЙТ СҮРЭГТ ТАВАН ТӨРЛИЙН МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ

	2007	2008	2009	2010	2011	2012
Тэмээ	0.2	0.1	0.1	0.3	0.2	0.2
Адуу	3.4	3.0	3.1	4.1	4.3	4.2
Үхэр	11.3	9.4	10.4	13.0	13.2	13.3
Хонь	44.3	47.2	48.8	51.1	48.7	50.7
Ямаа	40.7	40.2	37.6	31.6	33.7	31.7
Бүгд	100	100	100	100	100	100

2012 оны малын тоо толгойн өсөлт нь үндсэндээ үхэр, хонь сүргийн өсөлтөөр хангагдсан бөгөөд нийт өсөлтийн 8.8 хувийг хонь, 5.2 хувийг үхэр, 2.6 хувийг адууны өсөлт хангасан байна.

Нийт малын сүргийн бүтэцээс харвал 50.7 хувийг хонь, 31.7 хувийг ямаа, 13.3 хувийг үхэр, 4.2 хувийг адуу 0.2 хувийг тэмээ тус тус эзэлж байна.

НИЙТ СҮРЭГТ ТАВАН ТӨРЛИЙН МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ, 2012 ОН



ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО

	2008	2009	2010	2011	2012	2012/2011
Бүгд	161223	169487	129983	122465	129773	106
Ингэ	191	188	264	268	195	72.8
Гүү	2720	3159	3175	3380	3444	101.9
Үнээ	13262	15979	14728	15413	15523	100.7
Эм хонь	80162	85340	68197	62548	68822	110.0
Эм ямаа	64888	64821	43619	40856	41789	102.3

Хээлтэгч мал нийт малын 48.6 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн

44.9 хувь, адуун сүргийн 30.6 хувь, үхэр сүргийн 43.6 хувь, хонин сүргийн 50.6 хувь, ямаан сүргийн 49.1 хувийг тус тус эзэлж байна.

Мал аж ахуйн эрдэмтэн судлаачдын үзэж байгаагаар мал аж ахуйн нөхөн үйлдвэрлэлийг хэвийн хэмжээнд байлгахад хээлтэгч мал бод малын хувьд сүргийн 50-55 хувь, бог малын хувьд сүргийн 60-65 хувийг эзэлж байвал зохимжтой байна гэж үздэг бөгөөд сүүлийн жилүүдэд энэ харьцаа алдагдаж, сүүлийн 5 жилийн байдлаар хээлтэгч малын эзлэх хувь бод малд дунджаар 43.6, бог малд 49.1 хувь байна.

НИЙТ МАЛЫН ТООНД ХЭЭЛТЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ

	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Бүгд	46.6	47.0	45.0	46.7	46.9	52.0	47.7	48.4
Ингэ	43.7	42.4	42.7	38.1	42.7	36.8	52.9	44.9
Гүү	28.5	27.0	29.0	26.1	28.6	31.1	30.8	30.6
Үнээ	43.4	42.4	41.3	40.7	42.6	45.4	45.5	43.6
Эм хонь	50.1	48.8	46.8	49.2	48.3	53.4	50.0	50.6
Эм ямаа	46.1	48.5	45.4	46.8	47.7	55.3	47.2	49.1

ТӨЛ ӨГӨӨГҮЙ ХЭЭЛТЭГЧ

Сумын нэр	2010	2011	2012	Үүнээс					ОНЫ ЭХНИЙ ХЭЭЛТЭГЧИД ЭЗЛЭХ %	Өмнөх ОНООС ЗӨРҮҮ /- +/-
				Ингэ	Гүү	Үхэр	Эм хонь	Эм ямаа		
Дархан	9594	2323	1713	37	101	439	588	548	5.2	-610.0
Хонгор	9647	3198	2708	0	132	243	1163	1170	5.0	-490.0
Орхон	2117	740	1599	62	48	234	764	491	9.1	859.0
Шарын гол	3632	3144	3362	0	172	342	1284	1564	19.2	218.0
ДҮН	24990	9405	9382	99	453	1258	3799	3773	7.7	-23.0

ХЭЭЛ ХАЯСАН ХЭЭЛТЭГЧ

Малын төрөл	2000	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2012 /2011
										%
ДҮН	4741	1503	1275	1329	1286	1190	2499	1474	2997	2 дах
Ингэ	1	0	0	0	0	1	2	3	0	
Гүү	274	76	90	51	49	113	300	50	112	2 дах
Үнээ	873	280	124	45	51	64	640	97	142	146.4
Эм хонь	2177	387	617	658	467	368	4542	610	1000	163.9
Эм ямаа	1416	577	444	575	719	644	6571	714	1743	2 дах

2012 онд оны эхний төллөх насны хээлтэгч малын 2.4 хувьтай тэнцэх 2997 толгой мал хээл хаясаны улмаас төл өгөөгүй байна. Хээл хаясан малын тоо 2011 оныхоос 1523 толгойгоор буюу 2 дахин ихссэн байна.

Төл өгөөгүй нийт хээлтэгчийн 31.9 хувь буюу 2997 нь хээл хаясан хээлтэгч, үлдсэн 67.3 хувь буюу 6317 нь сувайрсан хээлтэгч, 0.7 хувь буюу 68 нь өнжсөн ингэ байна.

Сувайрсан малын тоо 2011 оныхоос 19.4 хувь буюу 1520 толгойгоор буурчээ.

СУВАЙРСАН ХЭЭЛТЭГЧ

Малын төрөл	2000	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2012 /2011
										%
ДҮН	6827	5482	2076	3562	5365	3150	12935	7837	6317	80.6
Ингэ	5	1	0	1	0	0	2	20	31	155.0
Гүү	640	282	193	163	265	348	412	226	341	150.9
Үнээ	1781	936	144	461	928	718	1899	1147	1116	97.3
Эм хонь	2801	2353	1142	1561	2266	933	5681	3777	2799	74.1
Эм ямаа	1600	1910	597	1376	1906	1151	4941	2667	2030	76.1

ХЭЭЛ ХАЯЛТ, СУВАЙРАЛТ



ХЭЭЛТҮҮЛЭГЧ МАЛЫН ТОО

Малын төрөл	2000	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2012 /2011
										%
ДҮН	1994	1330	1550	2004	2626	2689	1945	2147	2059	95.9
Буур	6	4	4	7	9	13	12	9	8	88.9
Азарга	484	264	293	279	369	396	378	415	414	99.8
Бух	347	169	190	231	304	384	325	351	328	93.4
Хуц	706	575	650	856	1112	1107	773	835	797	95.4
Ухна	451	318	413	631	832	789	457	537	512	95.3

2012 онд 2059 толгой хээлтүүлэгч мал тоологдож 2011 оныхоос 4.1 хувь буюу 88 толгойгоор буурсан.

НЭГ ХЭЭЛТҮҮЛЭГЧИД НООГДОХ ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО


Малын төрөл	Үржлийн норм	2000	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2012 /2011%
Ингэ	20-25	9	11	36	23	21	14	22	30	24	80
Гүү	12-15	8	8	7	8	7	8	8	8	8	100
Үнээ	35-45	39	50	47	47	44	42	45	44	47	107
Эм хонь	25-30	66	57	62	56	72	77	88	75	86	115
Эм Ямаа	25-30	58	73	80	68	78	82	95	76	82	108

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь бод малын хувьд үржлийн нормоор, харин бог малыг хувьд алдагдсан хэвээр байна. Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой атал 47 эм хонь, ямаа ногдож 86 хувиар өндөр үзүүлэлт гарч байна.

СҮРГИЙН БҮТЭЦ

	Мянган толгойгоор			Хувиар			Толгой	Хувь
	2010	2011	2012	2010	2011	2012	2012 /2011	2012 /2011
Бүгд	249.8	256.8	268.4	100.0	100.0	100.0	11.6	104.5
Төл өсвөр насны	86.0	92.1	95.2	34.4	35.9	35.5	3.1	103.4
Ажлын ба бэлтгэл насны	31.9	40.1	41.3	12.8	15.6	15.4	1.2	103.0
Хээлтэгч	130.0	122.5	129.8	52.0	47.7	48.4	7.3	106.0
Хээлтүүлэгч	1.9	2.1	2.1	0.8	0.8	0.8	0.0	100.0

СҮРГИЙН БҮТЭЦ, ХУВИАР, 2012 ОН



МАЛЫН СҮРГИЙН БҮТЭЦ, 2012 ОН

	Бүгд хувиар	Өсвөр насны төл	Ажлын ба бэлтгэл насны	Хээлтэгч	Хээлтүүлэгч	БҮГД
Дархан	100.0	28.9	12.9	37.4	0.6	79.8
Хонгор	100.0	43.6	18.7	62.1	0.9	125.3
Орхон	100.0	10.1	3.4	12.3	0.3	26.1
Шарын гол	100.0	12.6	6.3	18.0	0.3	37.2
ДҮН	100.0	95.2	41.3	129.8	2.1	268.4

2012 оны байдлаар нийт малын 35.5 хувь буюу 95.2 мянган толгой нь төл, өсвөр насны мал, 15.4 хувь буюу 41.3 мянган толгой нь нас гүйцсэн ажлын ба бэлтгэл насны мал, 48.4 хувь буюу 129.8 мянган толгой нь хээлтэгч мал, 0.8 хувь буюу 2.1 мянган толгой нь хээлтүүлэгч мал байна. 2012 онд өсвөр насны төлийн малын сүрэгт эзлэх хувь 3.4 пункт, ажлын болон бэлтгэл насны мал 3 пункт, хээлтэгч нь 6 пунктээр тус тус нэмэгдсэн байна.

II.2. МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА

2012 онд оны эхний нийт малын 71.1 хувьтай тэнцэх 182712 толгой малыг хэрэглээнд зарцуулсан байна. 2011 оныхоос 79425 толгой буюу 76.9 хувиар өссөн байна. Малтай нэг өрхийн дундажаар 76 толгой малыг хэрэглээнд зориулан зарцуулсан бол аймгийн хэмжээний нийт өрхөд харьцуулбал нэг өрх дундажаар 7 толгой малыг хэрэглээндээ зарцуулсан байна.

Оны эхний тэмээний 89.5 хувь, адууны 72.7 хувь, үхрийн 41.5 хувь, хонины 80.4 хувь, ямааны 69.1 хувийг хэрэглээндээ зарцуулсан байна.

Хэрэглээнд зарцуулсан малын 87.7 хувийг бог мал, 12.3 хувийг бод мал эзэлнэ. Сумаар авч үзвэл малаа хэрэглээндээ хамгийн ихээр зарцуулсан Хонгор сум 97.1 мянган толгой, Орхон сум 50.9 мянган толгой, Дархан сум 22.4 мянган толгой, Шарын гол сум 12.3 мянган толгойг тус тус зарцуулав.

МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА


Сумдын нэр	2010	2011	2012	Үүнээс				
				Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Дархан	47791	38197	22437	107	445	3737	9112	9036
Хонгор	44356	36359	97051	147	4056	6521	54612	31715
Орхон	32543	11757	50936	200	3354	2527	30487	14368
Шарын гол	27157	16974	12288	0	118	1268	6233	4669
ДҮН	151847	103287	182712	454	7973	14053	100444	59788

Сумдын нэр	Оны эхний малд эзлэх хувь						2012/2011	
	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	%	зөрүү
Дархан	50.8	51.6	14.3	45.6	56.8	48.8	58.7	-15760
Хонгор	35.0	0.0	13.7	27.9	42.0	27.6	2 дах	60692
Орхон	35.1	31.7	5.8	20.6	46.3	29.3	4 дах	39179
Шарын гол	45.8	0.0	23.7	30.9	54.2	41.3	72.4	-4686
ДҮН	41.4	43.9	14.5	33.6	48.4	36.6	94.8	-5358

II.3. ТӨЛ БОЙЖИЛТ

2012 оны байдлаар оны эхний төллөх насны хээлтэгчийн 91.1 хувь буюу 115892 толгой эх төллөж гарсан төлийн 98.8 хувийг буюу 119183 төл бойжуулав. Бойжсон төлийн тоо 2011 оныхоос 3094 толгойгоор буюу 2.7 хувиар нэмэгджээ.

Бойжуулсан төл, сумаар, /мян.тол/



Бойжуулсан төл, толгойгоор, олон жилээр

Онууд	Бүгд	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
1999	56707	2	2042	10056	30326	14281
2000	60430	9	1981	8932	33259	16249
2005	48719	3	1918	6778	22226	17794
2006	56288	19	1627	6904	27536	20202
2007	82302	66	1877	8561	39635	32163
2008	99980	87	1912	9390	47993	40598
2009	145372	104	2190	12163	73815	57100
2010	85969	115	2076	10575	45115	28088
2011	112662	141	2440	12517	60121	37443
2012	115756	111	2825	14389	60071	38360
2012/2011	102.7	78.7	115.8	115.0	99.9	102.4
Зөрүү	3094	-30	385	1872	-50	917

ТӨЛ БОЙЖИЛТ, СУМААР, ТАВАН ТӨРЛӨӨР, 2012 ОН

Сумын нэр	Бүгд	ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ					Бүгд	ХОРОГДСОН ТӨЛ				
		Ингэ	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа		Ингэ	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа
Дархан	33477	69	845	5450	15579	11534	287	2	40	85	58	102
Хонгор	52379	1	1352	4111	29895	17020	470	0	22	40	220	188
Орхон	16242	42	340	3298	7804	4758	609	18	22	129	286	154
Шарын гол	13794	0	316	1609	6944	4925	707	0	70	129	284	224
ДҮН	115892	112	2853	14468	60222	38237	2073	20	154	383	848	668

Сумын нэр	Бүгд	БОЙЖСОН ТӨЛ					Төлөлтийн хувь	Бойжилтын хувь	ӨНГӨРСӨН ОНЫ МӨН ҮЕ		
		Ингэ	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа			Төлийн хорогдол	Урьд онтой харьцуулсан %	Урьд оноос зөрүү /+-/
Дархан	33702	68	839	5432	15721	11642	91.2	98.7	142	64.5	-78
Хонгор	52084	1	1344	4093	29657	16989	94.4	99.6	300	144.9	93
Орхон	16417	42	340	3296	7844	4895	92.9	98.5	43	13.7	-274
Шарын гол	13553	0	302	1568	6849	4834	77.5	95.5	293	93.6	-20
ДҮН	115756	111	2825	14389	60071	38360	91.1	98.8	778	73.6	-279


100 ЭХЭЭС БОЙЖУУЛСАН ТӨЛ

	2000	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2012 /2011%
БҮГД	73	70	85	84	97	96	90	51	87	95	109.1
Ботго	30	0	20	42	46	53	54	61	53	41	77.5
Унага	52	66	79	77	89	83	81	66	77	84	108.8
Тугал	63	69	89	82	95	87	92	66	85	83	97.6
Хурга	75	73	81	84	98	100	92	53	88	96	108.9
Ишиг	79	68	88	87	97	95	88	43	86	94	109.4

Гарсан ботгоны 98.9 хувь, унаганы 98.4 хувь, тугалын 99.4 хувь, хурганы 99 хувь, ишигний 98.1 хувийг бойжуулсан байна. Бойжуулсан төл өмнөх оныхтой харьцуулахад унага 15.8 хувь буюу 385 толгой, тугал 15 хувь буюу 1872 толгой, ямаа 2.4 хувь буюу 917 толгойгоор тус тус нэмэгдэж, ботго 21.3хувь буюу 30 толгой, ишиг 0.1 хувь буюу 50 толгойгоор тус тус буусныг дээрх хүснэгтээс харж болно.

2006 онд 100 эхээс 84 төл бойжуулж байсан бол 2007 онд үүнээс 13 толгойгоор, 2008 онд 12 төлөөр, 2009 онд 6 төлөөр, 2011 онд 3 төлөөр, 2012 онд 11 төлөөр буюу 13.1 хувиар өсөж, 100 эх малаас 95 төл авсан байна. 2010 онд 33 төл буурч 100 эх малаас 51 төл авсан байна. Таван төрлөөр авч үзэхэд 2011 оныхоос тугал 2 төл буюу 2.4 хувь, ботго 12 төл буюу 22.5 хувиар тус тус буурсан байна. Унага 7 төл буюу 8.8 хувиар, хурга 8 төл буюу 8.9 хувь, ишиг 8 төл буюу 9.4 хувиар тус тус өслөө.

II.4. Том малын зүй бус хорогдол



2012 онд оны эхний нийт малын 0.8 хувьтай тэнцэх 2122 толгой мал хорогдсон нь 2011 оныхоос 165 толгойгоор буюу 7.2 дахин буурсан байна. Нийт хорогдсон малын 31.5 хувийг ямаа, 42.5 хувийг хонь, 18 хувийг үхэр, 7.1 хувийг адуу, 0.9 хувийг тэмээ эзэлж байна. Өвчнөөр 222 толгой мал хорогдсон нь нийт хорогдолын 10.5 хувийг эзэлж, 387 толгой хээлтэгч мал хорогдсон нь нийт хорогдолын 18.2 хувийг тус тус эзэлнэ.

ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ

	Өвчнөөр хорогдсон, бүгд				Зүй бус хорогдолд эзлэх хувь			
	2009	2010	2011	2012	2009	2010	2011	2012
Тэмээ	0	0	5	0	0	0	13.9	0
Адуу	1	6	10	19	3.2	1.4	10	12.6
Үхэр	110	19	27	37	43.7	0.5	12.8	9.7
Хонь	201	105	59	111	19.9	0.5	6.1	12.3
Ямаа	184	41	34	55	15.1	0.2	3.5	8.2
БҮГД	496	171	135	222	20.7	0.4	5.9	10.5

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, СУМААР

Сумын нэр	Хорогдол Бүгд	Үүнээс					2011 оны хорогдол	Оны эхний малд эзлэх
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа		
Дархан	287	2	40	85	58	102	831	0.4
Хонгор	519	0	19	38	274	188	328	0.5
Орхон	609	18	22	129	286	154	595	1.7
Шарын гол	707	0	70	129	284	224	533	1.9
ДҮН	2122	20	151	381	902	668	2287	0.8

Сумдаар авч үзвэл зүй бусаар хорогдсон малын тоог авч үзвэл Хонгор, Орхон, Шарын гол суманд 2.4-58.2 хувиар хорогдол өссөн байгаа боловч Дархан сумын хорогдол 65.5 хувиар буусан нь аймгийн хэмжээний хорогдлын дүн буурахад нөлөөлсөн болно.

Энэ онд том малын зүй бус хорогдолд өвчнөөр хорогдсон мал 2011 оныхоос 4.6 пунктээр өссөн байна.

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ

	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Бүгд	529	276	292	211	1869	46122	2287	2122
Тэмээ	0	0	1	6	2	34	36	20
Адуу	91	38	23	24	31	438	100	151
Үхэр	88	59	53	61	245	4151	211	381
Хонь	211	95	132	55	797	19142	971	902
Ямаа	139	84	83	65	794	22357	969	668

ОНЫ ЭХНИЙ МАЛД ЗҮЙ БУС ХОРОГДЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ

	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2012 /2011
Бүгд	0.4	0.2	0.1	0.1	0.5	18.5	0.9	0.8	88.8
Тэмээ	0.0	0.0	0.3	1.2	0.5	4.7	7.1	4.6	64.9
Адуу	1.2	0.5	0.3	0.2	0.3	4.3	0.9	1.3	147.2
Үхэр	0.5	0.3	0.2	0.2	0.7	12.8	0.6	1.1	171.7
Хонь	0.3	0.1	0.1	0.0	0.5	15.0	0.8	0.7	85.4
Ямаа	0.3	0.1	0.1	0.0	0.6	28.4	1.1	0.8	70.1

Дээрхи олон жилийн динамик үзүүлэлтээс харахад зүй бус хорогдолын оны эхний малд эзлэх хувийн жин 2005 онтой харьцуулахад 2006-2008 оны хооронд буурсан, 2009-2011 оны хооронд өсөж, 2012 оны хувьд 1 дахин өссөөр ирж 2012 онд өмнөх оныхоос 11.2 пунктээр буурсан байна.

II.5. ИРГЭДИЙН ХУВИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ

Иргэдийн хувийн малын бүлэглэлт

	Малтай өрхийн тоо			Дүнд эзлэх хувь			Малын тоо		
	2010	2011	2012	2010	2011	2012	2010	2011	2012
10 хүртэлх малтай	1186	965	863	39.2	35.1	35.8	5249	4791	4759
11-30 малтай	544	556	474	18.0	20.2	19.7	9052	8330	8519
31-50 малтай	224	222	168	7.4	8.1	7.0	7912	8081	6694
51-100 малтай	325	235	231	10.7	8.5	9.6	20264	16423	16846
101-200 малтай	337	332	253	11.1	12.1	10.5	43020	43206	36629
201-500 малтай	303	336	302	10.0	12.2	12.5	82741	93135	94779
501-999 малтай	93	88	95	3.1	3.2	3.9	52071	54679	61740
1000-1499 малтай	14	18	26	0.5	0.7	1.1	16012	20345	28834
1500-2000 малтай	3	0	0	0.1	0.0	0.0	5256	0	0
2000 дээш малтай	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0
ДҮН	3029	2752	2412	100.0	100.0	100.0	241577	248990	258800

Мал бүхий 2412 өрхийг малын тоогоор нь бүлэглэн авч үзвэл, 35.8 хувь буюу 863 өрх нь 10 хүртэл малтай: 19.7 хувь нь буюу 474 өрх нь 11-30 малтай: 7 хувь буюу 168 нь 31-50 малтай: 9.6 хувь буюу 231 нь 51-100 малтай: 10.5 хувь буюу 253 нь 101-200 малтай: 12.5 хувь буюу 302 нь 201-500 малтай: 3.9 хувь буюу 95 нь 501-999 малтай: 1.1 хувь буюу 26 нь 1000-1499 малтай өрх байна.

Мөн 2012 онд нийт малтай өрхөд 10 хүртэл толгой малтай өрхийн эзлэх хувийн жин өмнөх оныхоос 0.7 пункт, 1000-аас дээш толгой малтай өрхийн эзлэх хувийн жин 0.45 пунктээр тус тус өссөж, 11-100 хүртэл малтай өрхийн эзлэх хувийн жин 0.6 пункт, 101-1000 хүртэл малтай өрхийн эзлэх хувийн жин 0.6 пунктээр тус тус буурчээ.

НЭГ ӨРХӨД НОГДОХ ХУВИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ

	БҮГД	Үүнээс					2011 он бүгд	2012 /2011
		тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа		
10 хүртэлх малтай	6	0	0	5	0	0	5.0	111
11-30 малтай	18	0	1	13	2	2	15.0	120
31-50 малтай	40	0	3	17	8	11	36.0	109
51-100 малтай	73	0	6	19	22	27	70.0	104
101-200 малтай	145	0	5	19	63	58	130.0	111
201-500 малтай	314	1	12	25	163	113	277.0	113
501-999 малтай	650	0	25	37	408	180	621.0	105
1000-1499 малтай	1109	1	58	49	664	338	1130.0	98
1500-2000 малтай	0	0	0	0	0	0	0.0	0
2000 дээш малтай	0	0	0	0	0	0	0.0	0
Нэг өрхөд ноогдох малын тоо	107	0	5	15	53	35	90.0	119

МАЛТАЙ НЭГ ӨРХӨД НОГДОХ ХУВИЙН МАЛЫН ТОО

	Бодод шилжүүлснээр			Толгойн тоогоор		
	2010	2011	2012	2010	2011	2012
Дархан	21	22	28	61	59	81
Хонгор	25	30	15	128	159	180
Орхон	37	45	96	58	79	74
Шарын гол	23	23	24	74	75	78
ДҮН	26	28	33	80	90	107

Аймгийн дунджаар мал бүхий нэг өрхөд 89 толгой мал ногдож байгаа нь өмнөх оныхоос 1 толгой малаар багассан. Малтай нэг өрхөд тэмээ 0, адуу 5, үхэр 14, хонь 53, ямаа 35 ногдож байна.

Нэг өрхөд ногдох малын бүтцийг авч үзэхэд 82.2 хувь нь бог мал, 17.8 хувь нь бод мал байна.

Мал бүхий өрхийн дүнд дийлэнх хувийг эзэлж байгаа 200 хүртэл толгой малтай нэг өрхөд дунджаар 37 толгой, 201-999 малтай нэг өрхөд 394 толгой, 1000-1499 талтай нэг өрхөд 1109 толгой мал тус тус ногдож байна.

Малтай нэг өрхөд ногдох малын тоо бүх сумуудад 3-22 толгойгоор нэмэгдэв.

II.6. ШИНЭЭР ГАРГАСАН ХУДАГ

Монгол Улсын Засгийн газраас усны нөөц эх үүсвэрийг зохистой ашиглах замаар хүн ам, малын усны хангамжийг нэмэгдүүлэх, бэлчээрийн ашиглалтыг сайжруулахад анхаарал хандуулж, худаг, уст цэгийг шинээр гаргах, сэргээн засварлахад зориулан тодорхой хэмжээний хөрөнгө зарцуулж байна.

2005 оноос эхлэн мал тооллоготой хамтатган шинээр гаргасан, засварласан хулгийн талаархи мэдээллийг цуглуулан авч нэгтгэн гаргаж байна.

2012 онд нийт 7 худаг шинээр ашиглалтанд орсноос бүгд инженерий хийцтэй худаг байна.

Шинээр гарсан худгийн 42.9 хувь нь Дархан суманд, 57.1 хувь нь Хонгор сумууд эзэлнэ. Шинээр худаг гаргахад нийт 87855.5 мянган төгрөг зарцуулсны 25.6 хувь нь улсын төсвийн хөрөнгөөр, 74.4 хувь нь гадаад орон, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр санхүүжигдсэн байна.

Дархан –Уул аймгийн 2012 онд шинээр гаргасан худгийн тайлан

Сумдын нэр	Шинээр гаргасан худгийн тоо, бүгд /2+6/	Үүнээс					Шинээр худаг гаргахад зарцуул-сан хөрөнгийн хэмжээ /мян.төг/	Үүнээс			Худаг шинээр гаргахад түр ажилласан орон нутгийн иргэдийн тоо**
		Инженерийн хийцтэй/3+4+5/	Үүнээс			Энгийн уурхайн		Улсын төсвийн хөрөнгөөр /мян.төг/	Гадаад орон, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр /мян.төг/	Малчид иргэдийн өөрийн хөрөнгөөр /мян.төг/	
			Өрөмдмөл	Богино яндант	Бетон хашлагат						
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Дархан	3	3	3				33700.0	22500.0	11200.0		8
Хонгор	4	4	4				54155.5		54155.5		9
ДҮН	7	7	7	0	0	0	87855.5	22500.0	65355.5	0	17

Дархан-Уул аймагт 2012 онд засварласан худгийн тайлан

Сумдын нэр	Шинээр гаргасан худгийн тоо, бүгд /2+6/	Үүнээс					Шинээр худаг гаргахад зарцуул-сан хөрөнгийн хэмжээ /мян.төг/	Үүнээс			Худаг шинээр гаргахад түр ажилласан орон нутгийн иргэдийн тоо**
		Инженерийн хийцтэй/3+4+5/	Үүнээс			Энгийн уурхайн		Улсын төсвийн хөрөнгөөр /мян.төг/	Гадаад орон, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр /мян.төг/	Малчид иргэдийн өөрийн хөрөнгөөр /мян.төг/	
			Өрөмдмөл	Богино яндант	Бетон хашлагат						
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Шарын гол	3	3	3				19064.3		17157.9	1906.4	6
ДҮН	3	3	3	0	0	0	19064.3		17157.9	1906.4	6

II.7. МАЛЖУУЛАЛТЫН ТАЛААР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

Монгол Улсын Засгийн газрын ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд малгүй болон мал цөөнтэй иргэдийг малжуулах арга хэмжээ авч, нилээдгүй хөрөнгө, мөнгийг зарцуулж байна. Малжуулах арга хэмжээ нь орон нутаг, гадаад улс орон, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага зэрэг олон төрлийн байгууллагын санхүүжилтээр хийгдэж байна. 2012 оны байдлаар аймгийн хэмжээнд 9 өрх малжуулах арга хэмжээнд хамрагдсан бөгөөд нэг өрхийн ам бүлийн тоо дунджаар 4 байна. 2012 оны хувьд Хонгор суманд малжуулах арга хэмжээнд хэрэгжсэн байна.

Малжуулах арга хэмжээгээр 9 өрхөд нийт 250 толгой мал олгогдсон бөгөөд олгосон малын 80.8 хувь нь бог мал, 19.2 хувь нь бод мал байна. Нэг өрхөд дунджаар 28 толгой мал ногдож байна.

2012 онд малжуулах арга хэмжээнд нийт 25040 мянган төгрөг зарцуулсан бөгөөд үүнийг 3500.0 мянган төгрөг гадаад орон, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр 21540.0 мянган төгрөг бусад хэлбэрээр санхүүжүүлсэн байна.

Дархан-Уул аймгийн 2012 онд малжуулалтын талаар авсан арга хэмжээний тайлан

Сумдын нэр	Нийт зарцуулсан хөрөнгийн хэмжээ, бүгд /мян.төг//2+3+4/	үүнээс			Малжуулалтаар авсан малын тоо/6+7/	үүнээс		Малжуулалтанд хамрагдсан	
		Гадаад орон олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр/мян.төг/	Орон нутгийн хөрөнгөөр /мян.төг/	Бусад /мян.төг/		Бодын тоо	Богийн тоо	өрхийн тоо	ам бүлийн тоо
а	1	2	3	4	5	6	7	8	9
Дархан									
Хонгор	25040.0	3500.0		21540.0	250	48	202	9	36
Орхон									
Шарын гол	0	0	0	0	0	0	0	0	0
Дүн	25040.0	3500.0	0.0	21540.0	250.0	48.0	202.0	9.0	36.0

II.8. Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж,

2012 онд аймгийн хэмжээгээр 29261.3 тонн тэжээл үйлдвэрлэсэн нь өмнөх оныхоос 0.2 хувь буюу 45.4 тонноор өслөө.

Тэжээл бэлтгэл

	2008	2009	2010	2011	2012	2012/2011
Хадлан өвс	54030	54747.3	59277.8	54703	60121.6	109.9
Таримал тэжээл	30	95.1	68.5	51.4	56.8	110.5
Даршны ургамал	390	350	750	1041	1100	105.7
Гар тэжээл, хужир шүү	1236	1410.8	945.4	750.4	760	101.3
Төмс хүнсний ногооны хаягдал	49.5	262.9	70.2	85	85	100
Үр тарианы хаягдал	148	857.7	332.4	98	93	94.9
Лай	0	0	0	0	0	0
Сүрэл	76.5	85	80	200.2	250	124.9
Үйлдвэрлэсэн тэжээл бүгд (тэж.нэгж шилжүүлсэн)	25068.5	27568.6	28121.8	29215.9	29261.3	100.2

Тэжээл хангамж

	2008	2009	2010	2011	2012	2012/2011=%
Үйлдвэрлэсэн тэжээл бүгд (тэж.нэгж шилжүүлсэн)	25068.5	27568.6	28121.8	29215.9	29261.3	100.2
Нийт малыг хонин толгойд шилжүүлсэн /Мянган тол/	558.9	603.8	468.3	485.3	507.2	104.5
Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл, тэж.нэгж, кг	44.8	45.6	60	60.2	57.7	98.8

II.9. Малчдын нийгэм, ахуйн үзүүлэлт

Малчдын ахуй, соёлын зарим үзүүлэлт, өрхийн тоогоор, жилээр

	Өрхийн тоо						Малчин өрхийн тоонд эзлэх хувь					
	2007	2008	2009	2010	2011	2012	2007	2008	2009	2010	2011	2012
Цахилгаантай	940	1071	1106	1133	1245	901	96.3	95.5	84.5	94	94.6	95.7
Телевизортой	895	1121	796	1175	1265	742	91.7	100	60.8	97.5	96.1	78.9
Автомашинтай	427	656	527	705	1237	730	43.7	58.5	40.3	58.5	94	77.6
Мотоцикльтой	114	174	146	142	337	236	11.7	15.5	11.2	11.8	25.6	25.1
Худагтай	101	71	110	115	98	438	10.3	6.3	8.4	9.5	7.4	46.5


2012 оны тооллогоор нийт малчин өрхийн 87.6 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 78.9 хувь нь телевизортой, 77.6 хувь нь авто машинтай, 25.1 хувь нь мотоцикльтой, 46.5 хувь нь худагтай гэсэн дүн гарсан байна.

Сүүлийн жилүүдэд малчин өрхийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг нарны зайн эрчим хүчээр хангах арга хэмжээг авч явуулсны үр дүнд цахилгаан үүсгүүртэй өрхийн тоо жилээс жилд нэмэгдсээр байна.

Сүүлийн жилүүдэд төврүү шилжих хөдөлгөөн ихэссэнтэй холбоотой малчин өрхийн тоо багасч улмаар цахилгааны эх үүсгүүртэй өрх болон телевизтой, авто машин өрхийн тоо буурлаа.

МАЛЧДЫН СОЁЛ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Малчдын нийгэм ахуйн үзүүлэлт



МАЛЧДЫН АХУЙ, СОЁЛЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ


/өрхийн тоогоор,2012/

Сумын нэр	Баг, хорооны тоо	вэртэй өрх	Үүнээс				Телевизортой өрх	Мэвчин хашаатай өрх
			Нарны	Салхины	Бага оврын цах /үүсүүр /мотор/	бусад		
Дархан	10	226	175	0	0	117	205	276
Хонгор	3	326	254	3	0	69	283	378
Орхон	2	149	84	1	1	63	134	153
Шарын гол	3	134	117	1	2	14	120	134
ДҮН	18	901	630	5	3	263	742	941

МАЛЧДЫН НИЙГМИЙН АСУУДАЛ, ОЛОН ЖИЛЭЭР

		Хэмжих нэгж	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2012/2011	
										хувь	зөрүү
Малтай өрх		тоо	2428	2282	2546	2746	3029	2752	2412	87.6	-340
Малчин өрх		тоо	1113	976	1121	1309	1218	1316	941	71.5	-375
Малчдын тоо		тоо	2016	2244	2521	2822	3206	3784	1837	48.5	-1947
Үүнээс:	16-34 насны	хүн	764	652	845	987	904	981	577	58.8	-404
	35-аас тэтгэврийн нас хүртэл	хүн	876	1013	1119	1223	1616	1986	1037	52.2	-949
	Тэтгэвэрийн насны	хүн	376	579	557	612	686	817	223	27.3	-594
Нийт малчдаас эмэгтэй		хүн	658	986	1291	1136	1321	1673	804	48.1	-869
Насны бүтэц хувь		%	100	100	100	100	100	100	100	-	-
Үүнээс:	16-34 насны	%	37.9	29.1	33.5	35	28.2	25.9	31.4	-	5.5
	35-аас тэтгэврийн нас хүртэл	%	43.5	45.1	44.4	43.3	50.4	52.5	56.4	-	3.9
	Тэтгэвэрийн насны	%	18.6	25.8	22.1	21.7	21.4	21.6	12.1	-	-9.5

МАЛЧДЫН БҮТЭЦ, ХУВИАР, 2012 ОН



II.10. МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХ, МАЛЧДЫН ТОО НАСНЫ БҮЛГЭЭР

Сумдууд	Малтай өрхийн тоо	Малчин өрхийн тоо	16-гаас дээш насны малчдын тоо	малчид насаар			Эмэгтэй малчид
				16-34 настай	35-59 насны эр, 35-54 насны эм	Эр 60, эм 55-аас дээш насны	
Дархан	933	276	545	168	322	55	265
Хонгор	677	378	727	253	402	72	271
Орхон	350	153	308	75	177	56	146
Шарын гол	452	134	257	81	136	40	122
Дүн	2412	941	1837	577	1037	223	804


Аймгийн хэмжээгээр 2012 онд мал тооллогын дүнгээр мал бүхий 2412 өрх тоологдсон байна. Үүний 39 хувь буюу 941 өрх нь жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа малчин өрх, 61 хувь буюу 1471 өрх нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй өрх байна.

2012 онд дүнгээр 1837 малчид мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байгаа бөгөөд малчдыг насны бүлгээр авч үзвэл 31.4 хувь нь 16-34 настай, 56.4 хувь нь 35-59 насны 12.1 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна.

Сүүлийн жилүүдэд малчдын дотор 16-34 насны залуу малчдын эзлэх хувийн жин буурч, тэтгэврийн насны малчдын эзлэх хувийн жин өсөж байна.

2012 онд малчин өрхийн тоо 2011 оныхтой харьцуулахад 28.5 хувь буюу 375 өрхөөр бууржээ.

II.11. МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХИЙН ТОО, СҮҮЛИЙН ТАВАН ЖИЛЭЭР



**МАЛТАЙ ӨРХ БОЛОН МАЛЧИН ӨРХИЙН ТОО, СУМААР,
СҮҮЛИЙН ДӨРВӨН ЖИЛЭЭР**

Сумын нэр	Малтай өрхийн тоо				Малтай өрхийн тоо			
	2009	2010	2011	2012	2009	2010	2011	2012
Дархан	1085	1186	1128	933	567	396	519	276
Хонгор	705	791	694	677	352	445	427	378
Орхон	432	572	465	350	181	210	218	153
Шарын гол	524	480	465	452	209	167	152	134
ДҮН	2746	3029	2752	2412	1309	1218	1316	941

II.12.ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН АЖИЛЛАХ ХҮЧ


ХАА-н салбарт ажиллагсадын аймгийн нийт ажиллагсадад эзлэх хувийн жин жилээс жилд буурч байгаад 2012 он 0.5 хувиар нэмэгдсэнийг доорх графикаас харж болно. 2011 онд нийт ажиллагсадын 63.2 хувийг эзлэх ба өмнөх оныхоос ХАА-н салбарын ажиллагсадын тоо 2.5 хувиар өссөн байна.

ХАА-н салбард ажиллагсалын тоо

мян.хүн

Салбар	2007	2008	2009	2010	2011	2012	2012/ 2011%
ХАА, ан ангуур, ойн аж ахуй	5.8	6.1	6.4	6.8	7.3	7.5	102.7
Аймгийн нийт дүн	28.2	33.3	34.1	34.7	36.8	32.1	87.2
ХАА-н салбарын эзлэх хувь	20.6	18.3	18.8	19.6	19.8	23.4	117.8

ХАА-Н САЛБАРД АЖИЛЛАГСАДЫН ЭЗЛЭХ ХУВЬ



ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗАРИМ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ДУНДАЖ ҮНЭ, ХАНШ

/төгрөгөөр/

	Хэмжих нэгж	2009	2010	2011	2012	2012 2011%
Ямааны ноолуур	кг	27000	40000	45000	40000	88.9
Адууны шир	ш	16000	23000	32000	34000	106.3
Үхрийн шир	ш	16000	23000	36000	33000	91.7
Хонины арьс	ш	3500	9000	17000	8000	47.1
Ямааны арьс	ш	1700	19500	21000	21000	100.0

III. ГАЗАР ТАРИАЛАН

Тариалсан талбай

Аймгийн хэмжээгээр 2012 онд нийт 15541 га-д тариалалт хийсэн нь 2011 оныхоос 1243 га-гаар буюу 8.7 хувиар өссөн байна.

2011 онд тариалсан талбайг ургамлын нэр төрлөөр авч үзвэл: 9050.9 га-д үр тариа, 1189.5 га-д төмс, 961.6 га-д хүнсний ногоон тариалсан нь өмнөх оныхоос төмс 187.7, хүнсний ногоо 44.9 га-гаар тус тус нэмэгдэж, үр тариа 1990.1 га-гаар багассан байна.

2011 онд тариалсан талбайн бүтцийг авч үзэхэд 58.2 хувийг үр тариа, 7.7 хувийг төмс, 6.2 хувийг хүнсний ногоо эзэлж байна.

Хураасан ургац

Аймгийн хэмжээнд 2012 онд 12821 тн үр тариа, 14208 тн төмс, 12929 тн хүнсний ногоо хурааж, 60121.6 тн өвс хадлан, 265.3 тн таримал тэжээл бэлтгэсэн нь 2011 оныхоос үр тариа 23.7 хувь, төмс 0.5 хувь, хүнсний ногоо 1.6 хувиар тустус буурсан байна. Байгалийн өвс хадлан 9.9 хувиар буюу 5418.6 тн-оор нэмэгдсэн байна.

ТАРИАЛСАН ТАЛБАЙ

/га/

	2007	2008	2009	2010	2011	2012	2012/ 2011%
Бүгд талбай	10781.9	8234.1	12064.4	13706.7	14297.9	15541	108.7
Үр тариа	2308	4858	8659	6823	11041.4	9050.9	82.0
Үүнээс буудай	2318.8	4840	8619	6440	10384.4	9050.9	87.2
Төмс	654.8	801.3	1085.4	960	1001.8	1189.5	118.7
Хүнсний ногоо	700.3	606	600	916.8	916.7	961.6	104.9

ХУРААСАН УРГАЦ

/тн/

	2007	2008	2009	2010	2011	2012	2012/ 2011%
Бүгд талбай	18013.9	23422.5	31871.2	29556.9	50995.2	43707.7	85.7
Үр тариа	1748.2	4132.6	9642.6	9737.6	16803.8	12820.8	76.3
Үүнээс буудай	1748.2	4122.6	9598.1	9147.7	16295.8	12820.8	78.7
Төмс	5703.8	11166.2	13626.6	13645.6	14276.5	14208	99.5
Хүнсний ногоо	9234.8	7505.8	7829.6	7829.5	13144.7	12928.9	98.4

ХУРААСАН УРГАЦ, СУМААР, ТӨРЛӨӨР

Сумын нэр	Үр тариа		Төмс		Хүнсний ногоо	
	Хураасан талбай	Авсан ургац	Хураасан талбай	Авсан ургац	Хураасан талбай	Авсан ургац
Дархан			160	2400	140	1680
Хонгор	8985.9	12640.8	400	4200	83	958.6
Орхон	65	180	580	6888	728.5	10184
Шарын гол			49.5	720	10.1	106.3
ДҮН	9050.9	12820.8	1189.5	14208	961.6	12928.9

Хураасан ургацыг сумаар авч үзвэл Хонгор сум га-гаас 14.1цн үр тариа, га-гаас 105 цн төмс, га-гаас 118.8 цн хүнсний ногоо хураан авсан нь нийт хураасан үр тарианы 98.6 хувь, төмсний 29.6 хувь, хүнсний ногооны 7.4 хувийг эзэлнэ. Үүний дараа Орхон сум га-гаас 27.7цн үр тариа, га-гаас 118.8цн төмс, га-аас 139.8 цн хүнсний ногоо хураан авсан нь нийт үр тарианы 1.4 хувь, төмсний 48.5 хувийг, хүнсний ногооны 78.8 хувийг тус тус эзэлнэ. Үлдсэн хувийг бусад сумууд эзлэх байна.

МАЛЫН ӨСӨЛТӨНД ГОЛЛОН НӨЛӨӨЛСӨН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2007	2008	2009	2010	2011	2012	2012/2011	
							%	зөрүү
Бойжуулсан төл	82302	99980	145372	85969	112662	115756	102.7	3094
100 эхээс бойжуулсан төл	97	96	90	51	87	95	109.2	8
Зүй бус хорогдол	292	211	1869	46122	2287	2122	92.8	-165
Хээлтэгчийн тоо	103728	161223	169487	129983	122465	129773	106.0	7308
Хээл хаясан	1329	1286	1190	2494	1474	2997	203.3	1523
Сувайрсан	3562	5365	3150	12935	7837	6317	80.6	-1520

ДҮГНЭЛТ

2012 онд цаг агаар тааламжтай, хэвийн байж, цас бага орж, том малын зүй бус хорогдол өмнөх жилийнхээс 7.2 хувиар буурч, бойжуулсан төлийн тоо өсч улмаар жилийн эцсийн мал тооллогын дүнгээр малын тоо 268.4 мянган толгойд хүрч, өмнөх оныхоос 11.6 мянган толгой буюу 4.5 хувиар өслөө. Гэвч, энэхүү өсөлт нь өмнөх жилийн өсөлтөөс 1.7 пунктээр өссөн байна. Үүний шалтгаан нь 100 эхээс бойжуулсан төлийн тоо 9.2 хувиар буюу 8 толгойгоор, хээлтэгчийн тоо 6 хувь буюу 7308 толгойгоор тус тус нэмэгдсэн зэрэг нөлөөлсөн байна.

Төрлөөр авч үзвэл тэмээний тоо 73, ямаа 1376 толгойгоор тус тус буурсанч, адуу 281, үхэр 1748, хонь 10979 толгойгоор тус тус өссөн малын тооны өсөлтөнд нөлөөллөө.

Аймгийн мал аж ахуйн салбарт 2012 онд нядалгааны жингээр 6885.9 тн мах 6218.3 тн сүү, 23.9 тн ноолуур, 151.7 тн хонины ноос, 3.7 тн хөөвөр, 7.4 тн хялгас, 1.4 тн эм ноос, 97.9 мянган ширхэг арьс шир үйлдвэрлэсэн байна.

Иймд орон нутагт бүс нутгийн тулгуур төв болон шаардлагатай газруудад нь мал аж ахуйн түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, эцсийн бүтээгдэхүүний жижиг, дунд үйлдвэрийг барьж байгуулах нь шаардлагатай байна.

2012 онд аминдаа малтай 2412 өрх байгаагийн 941 нь малчин өрх байна. Мал аж ахуйн салбарт нийт 1837 малчид ажиллаж байна.

Нэг малчин өрхөд дундажаар 107 толгой мал, үүний дотор адуу 12, үхэр 38, хонь 144, ямаа 90 ногдож байна.

Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлд цаашид нэг малын ашиг шим, чанарын үзүүлэлтэд анхаарлаа хандуулж, энэ чиглэлээр тодорхой арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ялангуяа мал аж ахуйн салбарт шинэчлэл хийж, ашиг шим өндөртэй мал өсгөж үржүүлэх, малыг суурин болон бэлчээрийн хосолсон маллагаанд шилжүүлэх, малчдын хөдөлмөрийг хоршуулах, бэлчээрийг усжуулахад чиглэсэн арга хэмжээ ихээхэн чухал байна.

2012 онд тариалсан талбайг ургамалын нэр төрлөөр авч үзвэл: үр тариа 9050.9 га, улаан буудай 9050.9 га, төмс 1189.5 га, хүнсний ногоо 961.7 га, малын тэжээл 397 га, рапс 3870.2 га-д тариаллаа. Аймгийн хэмжээгээр төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн тариалалт нэмэгдсэн байна. Тухайлбал: ургацын эцсийн мэдээгээр үр тариа 12820.8 тн, төмс 14208. тн, хүнсний ногоо 12928.9 тн,

тэжээлийн ургамал 1600 тн, техникийн ургамал 2150 тн, Өвс 60.1 мянган тонныг бэлтгэлээ.

Газар тариалангийн үйл ажиллагаанд байгаль, цаг уур ихээхэн нөлөөлж байгаа боловч цаашид ургац хураалтын хэмжээг боломжийн хэмжээнд байлгахын тулд га-гийн ургацыг нэмэгдүүлэх, үүний тулд чанартай сайн үр суулгах, ургац боловсролтын үед хортон шавьжтай тэмцэх, иргэдийн дунд тариалалт хийх, ургац хураах зэрэг асуудлаар сургалт, сурталчилгаа явуулж, мэдлэгийн дээшлүүлэх зэрэгт ихээхэн анхаарах шаардлагатай байна.

Хамгийн гол асуудал бол хөдөө орон нутагт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг хадгалах, боловсруулах, борлуулах чиглэлээр жижиг, дунд үйлдвэрүүдийг байгуулах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг бэлтгэх төвлөрсөн цэгүүд, хадгалах, хөргөх агуулах, зоорийг бий болгох, сэргээх нь чухал байна.

Бэлчээрийн мал маллагаанд нутгийн шилмэл омог үүлдрийн малыг өөр дотор шилж сонгон цэвэр үржүүлгийн арга хэрэглэх, нутгийн үүлдэр шилмэл омгийн малаар сайжруулах төв суурин газрын хувьд сүүний чиглэлийн үхэр, адуу, тэмээ, ямааны эрчимжсэн фермерийн аж ахуй байгуулж эрхлэхийг дэмжих.

Мал сүргийг байнгын даатгалд хамруулах, байгалийн гамшиг, зудын хохиролоос сэргийлэх арга хэмжээ авах.

Малчдын боловсрол, мэргэжилтэй залуу халааг бэлтгэх арга хэмжээ авах

Бэлчээрт ашиглагдахгүй байгаа хуучин хулаг, услалтын системүүдийг сэргээн засварлах

Бэлчээрийн даацад тохируулан малын тоо толгойг өсгөн үржүүлэх бодлого хэрэгжүүлэх, ялангуяа манай аймгийн нийт малын 50-аад хувийг эзэлдэн ямаан сүргийн тоо толгойн өсөлтийг хязгаарлах, бог малын хувьд өсгөж үржүүлж ирсэн уламжлалт харьцаа 75:25 хувь буюу 3 хонь 1 ямаа гэсэн харьцаагаа өсгөж үржүүлэхэд татварын бодлогоор зохицуулах нь зүйтэй.

Хадлан, тэжээл үйлвэрлэлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих зэрэг арга хэмжээнүүдийг авах шаардлагатай байна.

Ашигласан ном, материал

1. Дархан –Уул аймгийн Статистикийн эмхэтгэл 2012 он
2. Улсын Статистикийн эмхтгэл 2012 он
3. Хөдөө аж ахуйн салбар 2011 он, ҮСХороо
4. Албан ёсны болон захиргааны сар, улирал, жилийн эцсийн мэдээ
5. Аймгийн эдийн засаг, нийгмийн байдлын танилцуулга -2012 он
6. Дархан-Уул аймгийн Хөдөө аж ахуйн салбар, 2011 он
7. Хөдөө аж ахуйн 2011 оны улсын анх дугаар тооллого, 2012 он
8. "Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал" танилцуулга, 2012/12 сар
9. WWW.1212.mn